

Санхүүгийн аудитын газар

**Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний
албаны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Аудитын код: САГ-2017/200/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.gov.mn

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 262451 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Батсайхан

Утас: 261628, 99058761 Цахим хаяг: batsaikhanj@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Мөнгөн хөрөнгө	9
2.9.2	Зардал	9
2.9.3	Биет бус хөрөнгө	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.12	Шилэн дансны мэдээлэл	11
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	13
3.1	Мөнгөн хөрөнгө	14
3.2	Зардал	15
3.3	Биет бус хөрөнгө	16
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	17
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	17
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	19
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	22
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан	25
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	26

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/327
танай _____-ны № _____-т

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАНГАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА, ХУРАНДАА Л.БОЛД
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний алба нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус албаны дарга, хурандаа Л.Болд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүн, бусад тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Энэ тайлангийн 4 дүгээр хэсэгт аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хангалт үйлчилгээний албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний албаны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хүртлэх хугацаанд хийж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ахлах аудитор Ж.Батсайхан хариуцаж хэрэгжүүлэв.

Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний алба 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 01 дүгээр 25-ны өдөр төрийн аудитын байгууллагад 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 7-3/143 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний алба нь Ар тал, зэвсэглэл, инженер, техник эрхэлсэн орлогч даргын эрхлэх асуудлын хүрээнд Хил хамгаалах ерөнхий газрын бүтцийн нэгжүүд, бие бүрэлдэхүүний цалин, хангалт, үйлчилгээ, тус газрын үйл ажиллагааны болон төвлөрсөн арга хэмжээний санхүүжилтийг хариуцаж, албан ёсоор 20 чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна

Тус алба тайлант хугацаанд албаны стандартыг хангаж, хилчдийн цэргийн мэргэжлийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр дараах үр дүнд хүрсэн байна.

- ХХЕГ-ын бие бүрэлдэхүүний хангалт үйлчилгээ, цаг үеийн арга хэмжээг чиг үүргийн хүрээнд шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, соёлч, боловсон, шуурхай зохион байгуулан ажиллажээ.
- ХХЕГ-ын бие бүрэлдэхүүний ая тухтай орчинд ажиллах нөхцлийг ханган, чанар, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан хувцас хэрэглэл, тавилга, бичиг хэргийн материалаар хангах ажлыг зохион байгуулсан байна.

- Улирал, сарын хангалтуудыг урьдчилан тооцож, батлагдсан төсвийн дагуу гэрээт байгууллагуудаас бэлтгэж, зохих хэмжээний нөөцтэй байлган хангалтыг тасралтгүй явуулсан байна.
- ХХЕГ-ын бие бүрэлдэхүүний хувцасны хангалтыг батлагдсан нормын дагуу жилд 2 удаа хангаж ажиллажээ.
- ХХЕГ-ын бие бүрэлдэхүүний бичиг хэргийн хангалтыг жил улирлаар зохион байгуулж, гадаад дотоодын зочид төлөөлөгчдийг хүлээн авч ажлын уулзалт болон хүндэтгэлийн зоог барих арга хэмжээний бэлтгэл ажлыг холбогдох хэлтэстэй хамтран зохин байгуулсан байна.

Хангалт үйлчилгээний алба өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнүүлсэн байна. Энэхүү гэрээний биелэлтийн тайланаас үзэхэд тус алба тайлант хугацаанд тавьсан зорилго, зорилт, албан үүргээ хангалттай сайн биелүүлсэн байна.

Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Хангалт үйлчилгээний албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу тус тургуулийн дотоод хяналт, дотоод аудитын үйл ажиллагааг судалж үзэхэд дотоод хяналт хэвийн байна гэж дүгнэв.

Хангалт үйлчилгээний албаны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд энгийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Хангалт үйлчилгээний албаны санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн Санхүүгийн тооцоолох компаний "Acolous" санхүүгийн програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Хангалт үйлчилгээний албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр, 5 асуудал эрсдэл дунд, 2 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 15 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 6 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн байгууллагын хувьд төсөвт зардал гол үзүүлэлт байдагтай холбоотой юм.

Хангалт үйлчилгээний албаны 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,971.5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 119.4 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь тус алба өмнөх аудитуудаар зөрчилгүй дүгнэлт авч байсан, санхүү, бүртгэлийн ажилтнууд харьцангуй тогтвортой байгаатай холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 3 чиглэлээр 5 эрсдэлтэй асуудалд 6 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Хэрэгжүүлсэн нийт горим сорилоос 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон 1 асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой асуудал гараагүй болно.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	3	13,37	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	3	13,37	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Аудитын явцад Хангалт үйлчилгээний албаны кассад байгаа бэлэн мөнгийг тоолж, үлдэгдэл гүйлгээг тулган баталгаажуулахад 2017 оны 2 дугаар сарын кассын орлого, зарлагын гүйлгээг кассын дэвтэрт хөтлөлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 7.2 дах заалт "Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж, кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна." гэсэн заалтыг зөрчсөн байна

Гаргасан шийдэл:

Касс дах мөнгөн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын журам, дүрмийг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

2.9.2 Зардал

Хангалт үйлчилгээний албаны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээс үзэхэд зочин төлөөлөгч болон хөдөө орон нутгаас албан томилолтоор ажилласан албан хаагчдын байр, хоол зэрэг томилолт, бусад нэгдсэн арга хэмжээний 12.82 сая төгрөгийн зардлыг байрны түрээсийн зардал нэрээр бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь батлагдсан зардлыг зориулалт бусаар зарцуулах зайлшгүй нөхцөл шаардлагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтыг биелүүлээгүй, төсвийн төлөвлөлтийг үндэслэлгүй төлөвлөж, батлуулсантай тус тус холбоотой байна.

Гаргасан шийдэл:

Ажил гүйлгээг үнэн бодитой үнэлж, нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах зөвлөмж өгөх

2.9.3 Биет бус хөрөнгө

Тус албаны 2016 оны санхүүгийн тайланд тусгасан 47.3 сая төгрөгийн програм хангамжийн ашиглалтын байдалд судалгаа хийж үзэхэд 550.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 програм хангамж лицензийн хугацаа дууссан шалтгаанаар ашиглалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16 –д заасан үндсэн хөрөнгийг үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байх, тухайн хөрөнгөнд холбогдох эдийн засгийн

ирээдүйн үр өгөөжийг тухайн байгууллага хүртэх боломжтой байх зарчимтай нийцэхгүй байна.

Гаргасан шийдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийн данс бүртгэлээс хасах зөвлөмж өгөх

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны чиглэлийг хууль, тогтоомжид бүрэн нийцэж байгаа эсэхийг үйл ажиллагаа тус бүрээр нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийсэн.

Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний албаны бүтэц, орон тоо, чиг үүрэг Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2016 оны н/36 дугаар тушаалаар батлагдсан боловч хуулийн этгээдийн хувьд албан ёсны нэр, статусыг баталгаажуулагүй тул төрийн бусад байгууллагатай харьцахдаа олон янзын нэрээр албаны нэрийг нэрэлдэг байна. Тухайлбал энэ алба Хил хамгаалах ерөнхий газар гэсэн нэртэй улсын бүртгэлийн бүртгэлийн гэрчилгээтэй бөгөөд ерөнхий газраасаа тусдаа өөр регистрийн дугаартай байна. Харин татвар, нийгмийн даатгал зэрэг байгууллагад Хил хамгаалах ерөнхий газрын аппарат гэсэн нэрээр бүртгэлтэй байна.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хангалт үйлчилгээний албаны өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 5,679.5 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	5,679.5	5,655.7	23.8	0.41
1.1	Урсгал зардал	5,679.5	5,655.7	23.8	0.41
1.2	Хөрөнгийн зардал				
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл				
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	5,679.5	5,655.7	23.7	0.41
2.1	Улсын төсвөөс санхүүжих	5,664.1	5,640.4	23.7	0.41

2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	15.4	15.4

Төсөвт зардлын нийт гүйцэтгэл тайлант хугацааны эцэст 23,8 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан нь хангамж, бараа материалын зардлыг 7,5 хувь буюу 23.7 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хангамж, бараа материалын зардлын бүлэг ихээхэн хэлбэлзэлтэй байгаа бөгөөд энэ зардлын бүлэгт тээвэр, шатахууны зардал 75,9 сая төгрөгөөр хэмнэгдсэн боловч бичиг хэрэг, шуудан холбоо интернетийн төлбөр, ном хэвлэл авах, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс худалдан авах зардал 135,5-27,8 сая төгрөгөөр батлагдсан төсөв хэтэрсэн байна.

Тухайлбал: Хилийн ангиудад шаардлагатай бичиг хэргийн хэвлэмэл маягт, хилийн застав, харуулд ашиглагддаг хилийн албаны дэвтэр бусад шаардлагатай бичиг хэргийн материал худалдан авсантай холбоотой бичиг хэргийн зардал 13,5 сая төгрөгөөр, хилийн ангиудад хүргэх шуудан, богцын тариф өнгөрсөн онд 20-40 хувиар нэмэгдсэнтэй холбоотой шуудан холбоо, интернетийн зардал 27,8 сая төгрөгөөр тус тус батлагдсан төсөв хэтэрсэн байна.

Тайлант хугацаанд төсөвт зардлын хэлбэлзэл хэвийн хэмжээнээс их байгаа нь хил хамгаалах байгууллагын ажлын онцлог, түүний дотор үйлчилгээний албаны ажлын нөхцлөөс гадна төсвийн төлөвлөлт, хуваарийг үндэслэлтэй бодитой хийдэггүйтэй холбоотой байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Хангалт үйлчилгээний албаны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Хангалт үйлчилгээний албаны 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 8-4/532 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хил хамгаалах ерөнхий газрын Хангалт үйлчилгээний албаны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж,

баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хангалт үйлчилгээний албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хангалт үйлчилгээний албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Мөнгөн хөрөнгө

Илрүүлэлт

Аудитын явцад Хангалт үйлчилгээний албаны кассад байгаа бэлэн мөнгийг тоолж, үлдэгдэл гүйлгээг тулган баталгаажуулахад 2017 оны 2 дугаар сарын кассын орлого, зарлагын гүйлгээг кассын дэвтэрт хөтлөлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 7.2 дах заалт "Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж, кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн аудитын **Үнэн зөв байдал** буюу Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх батламж мэдэгдэл зөрчигдөх

Төрийн өмч хөрөнгийн үрэгдэх, үргүй зарцуулагдах

Зөвлөмж

Бэлэн мөнгөний гүйлгээ, бүртгэл, тайлагналд баримтлах Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж, түүнд тавих хяналтыг сайжруулахаас гадна дутуу бүртгэсэн ажил гүйлгээг кассын дэвтэрт бүртгэж, баримтжуулах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

3.2 Зардал

Илрүүлэлт

Хангалт үйлчилгээний албаны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээс үзэхэд зочин төлөөлөгч болон хөдөө орон нутгаас албан томилолтоор ажилласан албан хаагчдын байр, хоол зэрэг томилолт, бусад нэгдсэн арга хэмжээний 12.82 сая төгрөгийн зардлыг байрны түрээсийн зардал нэрээр бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь батлагдсан зардлыг зориулалт бусаар зарцуулах зайлшгүй нөхцөл шаардлагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтыг биелүүлээгүйтэй, төсвийн төлөвлөлтийг үндэслэлгүй төлөвлөж, батлуулсантай холбоотой байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн аудитын **Эрх ба үүрэг** буюу Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх батламж мэдэгдэл зөрчигдөх

Зөвлөмж

Төсвийн төлөвлөлтийг өөрийн чиг, үйл ажиллагаантай уялдуулан бодитой боловсруулах

Ажил гүйлгээг үнэн бодитой үнэлж, нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

3.3 Биет бус хөрөнгө

Илрүүлэлт

Тус албаны 2016 оны санхүүгийн тайланд тусгасан 47.3 сая төгрөгийн програм хангамжийн ашиглалтын байдалд судалгаа хийж үзэхэд 550.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 програм хангамж лицензийн хугацаа дууссан шалтгаанаар ашиглалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16 –д заасан үндсэн хөрөнгийг үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байх, тухайн хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг тухайн байгууллага хүртэх боломжтой байх зарчимтай нийцэхгүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн аудитын **Оршин байх** буюу Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

Зөвлөмж

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг зохих журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлж, данс бүртгэлээс хасах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>601,872,967.81</u>	<u>610,335,729.38</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	984.90	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	984.90	-
31110	Төгрөг	984.90	
33	АВЛАГА	7,498,384.41	1,545,627.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.15	0.16
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,822,110.71	-
335	Бусад авлага	3,676,273.55	1,545,627.14
3351	Байгууллагаас авах авлага	3,676,273.55	1,545,627.14
34	УРЬДЧИЛГАА	113,165,076.00	80,765,076.00
34600	Урьдчилж гарсан зардал	113,165,076.00	80,765,076.00
35	БАРАА МАТЕРИАЛ	481,208,522.50	528,025,026.08
351	Түүхий эд материал	45,000.00	-
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал	45,000.00	
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	24,065,118.27	34,153,674.42
354	Хангамжийн материал	457,098,404.23	493,871,351.66
35410	Бичиг хэргийн материал	43,459,592.68	53,823,149.21
35420	Аж ахуйн материал	132,815,375.67	153,002,079.99
35430	Сэлбэг хэрэгсэл	186,371,949.18	186,371,949.18
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	4,153,935.29	708,790.00
35470	Бусад хангамжийн материал	90,297,551.41	99,965,383.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>695,620,593.21</u>	<u>603,490,494.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	695,620,593.21	603,490,494.48
391	Газар		
392	Биет хөрөнгө	688,673,432.73	601,055,944.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,079,224,279.17	961,677,919.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(585,794,852.20)	(557,278,926.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	407,930,741.70	391,990,241.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(313,980,684.12)	(261,057,426.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	224,048,401.26	198,924,270.82
39215	Хуримтлагдсан элэгдэл	(137,965,761.02)	(156,627,446.91)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		

39217	Ном	15,211,307.94	23,427,312.73
393	Биет бус хөрөнгө	6,947,160.48	2,434,550.04
39301	Програм хангамж	47,261,442.00	47,261,442.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(40,314,281.52)	(44,826,891.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,297,493,561.02</u>	<u>1,213,826,223.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,577,465.59</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,577,465.59	-
413	Өглөг	6,577,465.59	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,060,667.31	
4136	Бусад өглөг	516,798.28	-
41361	Байгууллагад төлөх өглөг	516,798.28	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,290,916,095.43</u>	<u>1,213,826,223.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,290,916,095.43	1,213,826,223.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,217,360,014.86	1,217,360,014.86
51101	Өмч: - төрийн	1,217,360,014.86	1,217,360,014.86
512	Хуримтлагдсан үр дүн	73,556,080.57	(3,533,791.00)
51210	Өмнөх үеийн үр дүн	73,556,080.57	73,556,080.57
51220	Тайлант үеийн үр дүн		(77,089,871.57)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,297,493,561.02</u>	<u>1,213,826,223.86</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,400,728,546.56	5,858,542,482.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,896,011.79	78,256,012.77
120	Нийтлэг татварын бус орлого	25,896,011.79	78,256,012.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,197,157.79	78,256,012.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,378,975.97	78,256,012.77
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,818,181.82	
120009	Бусад орлого	1,698,854.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,374,832,534.77	5,780,286,470.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,366,893,334.77	5,648,715,610.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,134,295,400.00	5,648,715,610.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	232,597,934.77	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,939,200.00	116,822,077.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,939,200.00	62,910,477.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		49,998,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,913,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	14,748,783.03
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг		14,748,783.03
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,576,120,616.36	5,947,488,752.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,576,120,616.36	5,947,488,752.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,697,792,943.56	4,811,988,435.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,288,228,463.98	3,448,241,676.67
210101	Үндсэн цалин	3,115,948,463.98	3,292,877,428.63
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	172,280,000.00	155,364,248.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,604,507.84	78,172,444.62
210201	Тэтгэврийн даатгал	26,593,195.91	8,424,868.01
210202	Тэтгэмжийн даатгал	864,270.42	939,961.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,080,338.77	1,151,911.98
210204	Ажилгүйдлийн даатгал	202,191.46	210,683.09
210205	Эрүүл мэндийн даатгал	59,864,511.28	67,445,019.96

210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,575,600.00	12,821,400.00
210304	Байрны түрээс	10,575,600.00	12,821,400.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	165,337,855.60	209,972,387.58
210401	Бичиг хэрэг	39,244,258.20	47,686,082.63
210402	Тээвэр, шатахуун	79,616,116.00	74,083,101.47
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,195,784.40	52,460,667.65
210404	Ном, хэвлэл	3,099,700.00	860,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,181,997.00	21,251,433.73
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		13,631,102.10
2105	Нормативт зардал	99,570,254.05	166,276,774.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,136,700.00	5,906,400.00
210502	Хоол, хүнс	72,053,074.80	121,044,154.03
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,380,479.25	39,326,220.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,828,701.05	24,413,450.00
210604	Урсгал засвар	30,828,701.05	24,413,450.00
2107	Томилолт, зочны зардал	102,714,541.62	66,026,112.00
210701	Гадаад албан томилолт	18,683,112.00	1,211,901.00
210702	Дотоод албан томилолт	46,871,436.00	58,536,221.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	37,159,993.62	6,277,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	347,385,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		347,385,820.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	911,933,019.42	458,678,371.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	676,206,074.35	9,863,738.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,468,962.71	77,285,701.99
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	153,257,982.36	160,517,463.17
210904	Найдваргүй авлагын алдагдал		
210911	Төвлөрсөн арга хэмжээ		211,011,467.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	878,327,672.80	1,135,500,316.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	827,979,781.12	1,126,451,204.78
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	119,594,673.29	34,767,721.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	225,906,466.40	228,653,346.66
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		2,734,000.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	273,383,255.89	457,992,350.80
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,838,936.00	322,763,635.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	183,256,449.54	79,540,150.62
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,347,891.68	9,049,112.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,347,891.68	9,049,112.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(175,392,069.80)</u>	<u>(88,946,269.97)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	13,706,136.07	35,864,948.00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	13,706,136.07	35,864,948.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,700,831.25	24,008,549.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	18,700,831.25	24,008,549.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,994,695.18)	11,856,398.40
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(180,386,764.98)</u>	<u>(77,089,871.57)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>5,172,307,945.57</u>	<u>5,780,958,873.51</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,073,345.57	15,421,186.51
120	Нийтлэг татварын бус орлого	30,073,345.57	15,421,186.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,374,491.57	15,421,186.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,374,491.57	15,421,186.51
120009	Бусад орлого	1,698,854.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,142,234,600.00	5,765,537,687.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,142,234,600.00	5,711,626,087.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,134,295,400.00	5,648,715,610.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,939,200.00	62,910,477.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	53,911,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		49,998,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,913,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>5,107,642,742.33</u>	<u>5,638,904,299.41</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,107,642,742.33	5,638,904,299.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,220,599,605.63	4,496,044,517.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,267,136,370.00	3,387,991,000.00
210101	Үндсэн цалин	3,112,312,025.01	2,842,366,900.00
210102	Нэмэгдэл		140,444,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	154,824,344.99	405,179,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,304,303.00	66,674,900.00
210201	Тэтгэврийн даатгал	107,304,303.00	66,674,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,575,600.00	12,821,400.00
210304	Байрны түрээс	10,575,600.00	12,821,400.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	208,073,361.28	321,577,409.41
210401	Бичиг хэрэг	59,423,549.53	89,494,533.30
210402	Тээвэр, шатахуун	79,245,666.00	127,428,983.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,353,285.75	54,756,472.70
210404	Ном, хэвлэл	4,329,700.00	1,060,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,721,160.00	48,837,420.41
2105	Нормативт зардал	114,777,180.17	193,762,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,134,700.00	5,174,400.00
210502	Хоол, хүнс	88,442,471.09	109,572,414.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,200,009.08	79,015,756.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,828,564.18	14,932,038.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	138,000.00	
210604	Урсгал засвар	21,690,564.18	14,932,038.00
2107	Томилолт, зочны зардал	97,345,792.00	62,118,900.00
210701	Гадаад албан томилолт	18,897,852.00	2,259,501.00
210702	Дотоод албан томилолт	46,053,436.00	59,859,399.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	32,394,504.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		348,198,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		348,198,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	393,558,435.00	87,967,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	321,062,435.00	9,650,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,496,000.00	78,317,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	887,043,136.70	1,142,859,782.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	836,695,245.02	1,133,810,670.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	148,412,615.10	37,570,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	234,989,136.00	255,032,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		3,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	331,989,558.50	438,886,340.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,838,936.00	399,321,430.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	95,464,999.42	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,347,891.68	9,049,112.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,347,891.68	9,049,112.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>64,665,203.24</u>	<u>142,054,574.10</u>

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	64,684,218.35	142,055,559.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	64,684,218.35	142,055,559.00
2200	Дотоод эх үүсвэрээр	64,684,218.35	142,055,559.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	64,684,218.35	142,055,559.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(64,684,218.35)</u>	<u>(142,055,559.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(19,015.11)	(984.90)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000.00	984.90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	984.90	-

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,217,360,014.86	253,942,845.55	1,471,302,860.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,217,360,014.86	253,942,845.55	1,471,302,860.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн		-182,085,618.98	-182,085,618.98
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,217,360,014.86	73,556,080.57	1,290,916,095.43
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,217,360,014.86	73,556,080.57	1,290,916,095.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,217,360,014.86	73,556,080.57	1,290,916,095.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн		-77,089,871.57	-77,089,871.57
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,217,360,014.86	-3,533,791.00	1,213,826,223.86

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	984.90
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,679,557,983.02	5,655,788,669.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,679,557,983.02	5,655,788,669.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,540,723,313.02	4,516,953,999.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,387,991,000.00	3,387,991,000.00
210101	Үндсэн цалин	2,842,366,900.00	2,842,366,900.00
210102	Нэмэгдэл	140,444,300.00	140,444,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	405,179,800.00	405,179,800.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,674,900.00	66,674,900.00
210201	Тэтгэврийн даатгал	66,674,900.00	66,674,900.00
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,821,400.00	12,821,400.00
210301	Гэрэл, цахилгаан		
210302	Түлш, халаалт		
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс	12,821,400.00	12,821,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	315,718,953.02	291,949,639.41
210401	Бичиг хэрэг	79,008,900.00	92,538,733.30
210402	Тээвэр, шатахуун	145,663,400.00	69,704,906.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,025,200.00	54,876,472.70
210404	Ном, хэвлэл	-	16,620,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,021,453.02	58,209,527.41
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	204,236,560.00	204,236,560.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	5,174,400.00
210502	Хоол, хүнс	106,639,260.00	104,373,404.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	97,597,300.00	94,688,756.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,445,200.00	40,445,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга	19,180,400.00	18,446,360.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	
210604	Урсгал засвар	19,764,800.00	21,998,840.00
2107	Томилолт, зочны зардал	62,118,900.00	62,118,900.00
210701	Гадаад албан томилолт	-	2,259,501.00
210702	Дотоод албан томилолт	62,118,900.00	59,859,399.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	358,448,900.00	358,448,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	358,448,900.00	358,448,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,267,500.00	92,267,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,650,000.00	9,650,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,617,500.00	82,617,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,138,834,670.00	1,138,834,670.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,138,834,670.00	1,138,834,670.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,636,900.00	39,636,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	257,990,000.00	257,990,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	3,000,000.00	3,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	438,886,340.00	438,886,340.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	399,321,430.00	399,321,430.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,679,557,983.02	5,655,787,684.51
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,664,136,796.51	5,640,366,498.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,664,136,796.51	5,640,366,498.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,421,186.51	15,421,186.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,421,186.51	15,421,186.51
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		984.90
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		
620001	Удирдах ажилтан	353.00	353.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	330.00	330.00
620004	Гэрээт ажилтан	14.00	14.00